



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 24 өдөр

Дугаар

А/79

Мандалговь

Нээлттэй сонгон шалгаруулалт зохион  
байгуулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн “Дүрэм батлах тухай” А/256 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 3.2.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж байгаатай холбоотойгоор шинээр сонгогдох ёс зүйн салбар хорооны гишүүдийн нээлттэй сонгон шалгаруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

М.Халиунаа (Яаралтай, гамшгийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Р.Мөнхбаясгалан (Хүний нөөцийн мэргэжилтэн)

Гишүүд:

Д.Цэрэнчунт (Халдварт бус өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Сонгон шалгаруулалтын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар дамжуулан 21-ээс доошгүй хоногийн хугацаанд байршуулж, материалыг хүлээн авсугай.

3. Ирүүлсэн материалыг судлаж, шалгуур хангасан нэр дэвшигчийг сонгож, үр дүнг танилцуулахыг комиссын дарга (М.Халиунаа)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Handwritten signature and stamp of the Chairman

Б.АЛТАНТӨГС